

БАТЛАВ УЛААНБААТАР ХОТ
“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ

БАТЛАВ
“ЭКО БҮТЭЭМЖ ГРУПП” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ГИНДРА

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022 оны 11-р сарын 03-ны өдөр

№ 425 / 2022

Улаанбаатар хот

Нэг талаас Монгол улс, 13301, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 8-р хороо УС-15 1-1 тоотод бүртгэлтэй “Амгалан дулааны станц” ТӨХК /регистрийн дугаар: 6021646/ (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Анкарагийн гудамж, Корпорейшн тауэр, 4 давхар, 400 тоотод бүртгэлтэй 5508959 тоот регистрийн дугаартай “Эко бүтээмж групп” ХХК (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нар (цаашид тус тусад нь “Тал”, хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 8-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Амгалан дулааны станцыг 116 МВт-аар өргөтгөх төсөл”-ийн Байгаль орчны зөвлөх үйлчилгээ ажлыг холбогдох норм, стандарт, журмын дагуу хийж гүйцэтгэхэд энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.2. Гэрээт ажил нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:
 - 1.2.1. Бэлтгэл ажил
 - 1.2.2. Суурин судалгааны ажил
 - 1.2.3. Хээрийн судалгааны ажил
 - 1.2.4. 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан
 - 1.2.5. 2022 оны Байгаль орчны хяналт, мониторингийн тайлан
 - 1.2.6. Бэлэн болсон тайланг холбогдох байгууллагаар батлуулах
 - 1.2.7. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө гаргах

ХОЁР. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 2.1. Гэрээт ажлын нийт дүн 4 000 000 /Дөрвөн сая/ төгрөг болно. Тус үнийн дүнд НӨАТ багтсан болно.
- 2.2. Захиалагч нь энэхүү гэрээний нийт төлбөрийг ажлын тайлан, ажил хүлээлцэх актыг үндэслэн Гүйцэтгэгчийн нэхэмжлэлийн дагуу Худалдаа хөгжлийн банкны 472 001 482 тоот харилцах дансанд шилжүүлнэ.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 3.1. Гэрээний хугацаа 2022 оны 12-р сарын 20-ны өдөр дуусгавар болно.